



**МОНГОЛ УЛСЫН  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ**

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А-56

Улаанбаатар хот

┌ Стратеги төлөвлөгөө батлах тухай ┐


Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эдийн засаг хөгжлийн яамны 2022-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг нэгжийн дарга нарт, хэрэгжилтийн явцыг хагас бүтэн жилээр тайлагнахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Н.Орхон)-т тус тус үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Оюунчимэг)-т даалгасугай.


САЙДЫН ҮҮРЭГ  
ХАРИУЦАГЧИ



Б.ЖАВХЛАН

3

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022  
оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 16  
дугаар тушаалын ... дүгээр хавсралт



**ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2022-2024 ОН)**

Улаанбаатар хот

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА**

<b>Нэг.</b> Нийтлэг үндэслэл.....	5
<b>Хоёр.</b> Мандатын шинжилгээ .....	5-11
<b>Гурав.</b> Орчны шинжилгээ.....	11-12
<b>Дөрөв.</b> Алсын хараа .....	12
<b>Тав.</b> Эрхэм зорилго.....	12
<b>Зургаа.</b> Стратегийн зорилт.....	13
<b>Долоо.</b> Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам..	14-33

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү стратеги төлөвлөгөөг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулсан.

Тус стратеги төлөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн яамны ерөнхий чиг үүрэг болох хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, бүс нутаг, аж үйлдвэрийн бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлох, макро эдийн засгийн бодлогын судалгаа, хөрөнгө оруулалт, худалдаа, хилийн боомтын хөгжил, чөлөөт бүс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан гүйцэтгэх болон тэдгээрийн хэрэгжилтийг хангахтай холбогдох харилцааг хууль тогтоомжийн дагуу нэгдмэл, цогц, харилцан уялдаатай зохион байгуулах хэрэгцээ, шаардлагын хүрээнд боловсруулав.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Эдийн засаг, хөгжлийн яаманд хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд Мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

*Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт*

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		21	
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	1	Монгол Улсын Үндсэн хууль
		2	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
		3	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
		4	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
		5	Хөрөнгө оруулалтын тухай хууль
		6	Концессын тухай хууль
		7	Чөлөөт бүсийн тухай хууль
		8	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль
		9	Хилийн боомтын тухай хууль
		10	Төсвийн тухай хууль
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	11	Төрийн албаны тухай хууль
		12	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
		13	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
		14	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
		15	Шилэн дансны тухай хууль

		16	Хөдөлмөрийн тухай хууль
		17	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
		18	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
		19	Авлигын эсрэг хууль
		20	Захиргааны ерөнхий хууль
		21	Холбогдох бусад хуулиуд
<b>Ерөнхий чиг үүрэг-1.</b> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулах, удирдлага, зохицуулалтаар хангах болон хөгжлийн судалгаа хийх			
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх	
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого		
	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр		
	Хөгжлийн 7 зорилтот хөтөлбөр		
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр		
	Шинэ сэргэлтийн бодлого		
	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө		
<b>Үндсэн чиг үүрэг-2.</b> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийн хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд	
	Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж, зөвшөөрөл өгөх		
	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох		
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах		
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлэх		
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад төрийн бүх шатны болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх		
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх,		

	<p>чадавхжуулах</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журмыг боловсруулж, батлах</p> <p>Мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх</p>	
<p><b>Үндсэн чиг үүрэг-3.</b> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан, нэмж тусгах төсөл, хөтөлбөрийн бодлогын болон төслийн судалгаа техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах</p>	
	<p>Дэлхийн улс орнуудын туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх</p>	
	<p>Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай норм, норматив, стандартыг боловсруулах</p>	
	<p>Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи, арга хэрэгсэл ашиглах, судалгаа шинжилгээний хамтарсан арга хэмжээ зохион байгуулах, шаардлагатай арга хэмжээг тухай бүр хийж гүйцэтгэх</p>	
<p><b>Ерөнхий чиг үүрэг-2. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох</b></p>		
<p>Үндсэн чиг үүрэг</p>	<p>Дэд чиг үүрэг</p>	<p>Хамтран хэрэгжүүлэх</p>
<p><b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Макро эдийн засгийн бодлого, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох</p>	<p>Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл гаргаж, макро эдийн засгийн бодлогын судалгаа, төлөвлөлтийг хийж, эдийн засгийн тэнцвэрт харьцаа, тогтвортой байдлыг хангах</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд</p>
	<p>Урсгал болон хөрөнгө, санхүүгийн дансны гүйцэтгэлийг шинжлэн тооцоо, прогноз хийж, төлбөрийн тэнцлийг тодорхойлж, хөгжлийн бодлогын төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх</p>	
	<p>Улс орны эдийн засгийн хөгжлийн түвшнийг үнэлэх, эдийн засгийн судалгаа, шинжилгээ хийж, тооцоо судалгаанд үндэслэсэн макро эдийн засгийн бодлогын зохицуулалтын</p>	

	санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах	
<b>Үндсэн чиг үүрэг 2.</b> Зээл, тусламжийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, удирдлагаар хангах	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд үндэслэн гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлох,	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагууд
	Зээл, тусламжийн хязгаар, зохистой харьцааг тогтоох	
	Олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаад орноос авах зээл, тусламжийн нэгдсэн бодлого, хөгжлийн болон хөрөнгө оруулалтын бодлого болон салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих	
	Түнш орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллах	
<b>Ерөнхий чиг үүрэг-3. Бүс нутаг, аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах</b>		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх</b>
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Бүс нутаг, аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүйгээр хангах	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд
	Салбарын хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого болон төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг нягталж санал, дүгнэлт өгөх	
	Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын оролцоог өргөжүүлэх арга хэмжээг авах	
	Аж үйлдвэрийн хөгжил байршлыг тодорхойлж, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг хангах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах	
	Хөгжлийн ирээдүйтэй байршилд Кластераар аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого боловсруулах	
<b>Ерөнхий чиг үүрэг-4. Чөлөөт бүс, хилийн боомтыг хөгжүүлэх, чөлөөт бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дэмжих, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах</b>		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх</b>
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Чөлөөт бүсийн бодлогыг	Чөлөөт бүсийн хөгжлийн судалгаа, бодлого, төлөвлөлт хийж, хэрэгжилтэд хяналт тавих	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн

тодорхойлж, хөгжүүлэх, чөлөөт бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дэмжих	чөлөөт бүсийг салбаруудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж, нэгдсэн бодлогоор хангах	захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд,
	чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, бодлого, арга зүйгээр хангах	Захирагчийн ажлын албад
<b>Үндсэн чиг үүрэг-2.</b> Хилийн боомтын бодлогыг тодорхойлж, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах	Хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд
	Хилийн боомтын асуудлаарх Засгийн газрын баримтлах чиглэл, бодлогын Төрийн захиргааны бусад төв байгууллагуудтай хамтран шуурхай хэрэгжүүлэх, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах	
<b>Ерөнхий чиг үүрэг-5. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг дэмжих</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангах нэгдсэн бодлого төлөвлөх, удирдлага, зохицуулалтаар хангах	<p>Хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох</p> <p>Хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчдад сурталчлах</p> <p>Хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулж, хэлэлцээр хийх</p> <p>Хөрөнгө оруулалтын чиглэлээр нэгдэн орсон болон соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн талаар судалгаа хийх, санал боловсруулах</p> <p>Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах</p> <p>Хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэх, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх</p>	<p>Хамтран хэрэгжүүлэх</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд</p>
<b>Үндсэн чиг үүрэг-2.</b> Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, сурталчлах	<p>Гадаадын хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг сунгах хүсэлт болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбоотой тодорхойлолтыг холбогдох төрийн байгууллагад тухай бүр гаргаж өгөх</p> <p>Хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох, тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн улсын бүртгэл хөтлөх</p> <p>Холбогдох төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан мэдээллүүдийг хагас, бүтэн жилээр гаргуулж, хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах</p>	<p>Төрийн захиргааны байгууллагууд, хөрөнгө оруулагчид, иргэд, хуулийн этгээд</p>



	Нэг цонхны үйлчилгээг үзүүлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх	
<b>Үндсэн чиг үүрэг-3.</b> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх	Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгыг дэмжих, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төрөл, хэлбэрүүдийг өргөжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах	Төрийн захиргааны байгууллагууд, иргэн, хуулийн этгээд
	Төрийн өмчийн концессын зүйлийн талаар судалгаа хийж, санал боловсруулах, жагсаалтын талаар санал бэлтгэж, батлуулах, жагсаалтыг нийтэд мэдээлэх, концесс олгох	
	Уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, батлуулах, концессын гэрээний биелэлт, явц, үр дүн, концессын үйл ажиллагаанд хяналт тавих	
<b>Ерөнхий чиг үүрэг-6. Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогыг тодорхойлох, удирдлагаар хангах</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Худалдаа, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогыг тодорхойлох, Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Худалдаа, эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах, бодлого тодорхойлох	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагууд
	Худалдаа (гадаад, дотоод)-ны нэгдсэн бодлого, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих	
	Худалдааны статистик мэдээ гаргах, чөлөөт бүс, хилийн боомт дахь худалдааны эргэлтийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, тогтмол баяжуулж шинэчлэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх	
	Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай ажиллах	
<b>Ерөнхий чиг үүрэг-7. Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх
<b>Үндсэн чиг үүрэг-1.</b> Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, дотоод нэгжүүд
	Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Яамны стратеги төлөвлөгөөний биелэлтэд тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	

	Тус яамны хариуцан хэрэгжүүлэх Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тус газрын хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Зохион байгуулалтын шинжтэй бусад арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
<b>Үндсэн чиг үүрэг-2.</b> Төрийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах	Яамны дотоод бүтэц, зохион байгуулалтын нэгжүүд
	Яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, нэгжүүдийн тайланг нэгтгэх, хэрэгжилтийг зохион байгуулах	
	Яамны санхүү, аж ахуйн асуудлыг зохицуулах	
	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, гэрээ, хэлцлийн төсөл боловсруулах асуудлаар хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	
	Яамны гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаарх сурталчилгаа, олон нийтийн харилцааг зохицуулах	

### ГУРАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Эдийн засаг, хөгжлийн яамны ерөнхий чиг үүрэг тус бүрд орчны шинжилгээг гүйцэтгэж, шинжилгээний үр дүнг нэгтгэн, дор дурдсан байдлаар тодорхойлов.

*Хүснэгт 2. Орчны шинжилгээний нэгдсэн хүснэгт*

<b>Дотоод орчин</b>	
<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<p>1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай, нэгдсэн зохион байгуулалттай, нарийн төлөвлөгөөтэй, системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн.</p> <p>2.Мэргэшсэн төрийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг ажиллуулж, аливаа санал, хүсэлтийг ажлын 8 цагийн дотор шийдвэрлэж, хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	<p>1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн судалгааны байгууллагын гаргасан судалгаа, шинжилгээ дээр үндэслэн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг зөв оновчтой тодорхойлох эрх зүйн орчин бүрдсэн боловч уг судалгааны байгууллага болох Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулагдаагүй, энэ байгууллагын чиг үүргийг яамны 6 хүний орон тоотой Хөгжлийн судалгааны газар хэрэгжүүлж байна. Уг бүтцээр дээрх ерөнхий чиг үүргийг бүрэн хангалттай хэрэгжүүлэх боломжгүй байна.</p> <p>2.Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийн албан хаагчдын тухайн чиглэлээр мэргэшсэн байдал дутмаг байгаа нь чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлийг бий болгож байна.</p>
<b>Гадаад орчин</b>	
<b>Боломж</b>	<b>Эрсдэл</b>
<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус баталсантай холбогдуулан бодлого, төлөвлөлтийн нэгдсэн цогц арга хэмжээ авч, судалгаа шинжилгээний ажилд эрдэмтэн судлаачид, иргэд, хуулийн этгээдүүдийг оролцуулах замаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх боломж бий болсон.</p>	<p>Яамны чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчдын мэргэшсэн байдал хангалтгүй байгаагаас шалтгаалан Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.</p>

### **ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА**

Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааны тэргүүлэх төрийн захиргааны төв байгууллага болно.

### **ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийг төлөвлөх, хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг тогтвортой, хүртээмжтэй дээшлүүлэхэд оршино.

### **ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛТ**

6.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэсний, салбарын, салбар хоорондын, бүс, орон нутгийн уялдааг ханган боловсруулах, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нийгмийн хөгжлийн болон өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны нэгдсэн бодлогыг тодорхойлох;

6.2.Макро эдийн засгийн бодлого, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох;

6.3.Бүсчилсэн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн оновчтой байршлыг тогтоож, бүс, орон нутгийн хөгжлийг тодорхойлж, аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах, бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх;

6.4.Чөлөөт бүсийг хөгжүүлэх, чөлөөт бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дэмжих, хилийн боомтын бодлогыг тодорхойлж, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах;

6.5.Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, хөрөнгө оруулалт татах, сурталчлах, хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг үзүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цогц арга хэмжээг авч, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг тодорхойлж, төрийн өмчийн зүйлийг концессоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих;

6.6.Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогыг тодорхойлох, удирдлагаар хангах, энэ чиглэлээр хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

6.7.Зээл, тусламжийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, удирдлагаар хангах;

6.8.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор судалгаа, шинжилгээ хийх, шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийн бодлогын судалгаа, техник эдийн засгийн урьдчилсан судалгаа, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг хийх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хийгдэх бусад судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх, олон улсын арга туршлагыг судлан санал боловсруулах;

6.9.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн болон гадаад харилцааны асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах;

6.10.Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сайдын эрхлэх асуудлын хүрээний санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.ангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам

Зорилт	Хэрэгжүүлэх арга зам (стратегии)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүжилтийн хэмжээ /сая төгрөг/	Санхүүгийн эх үүсвэр
<b>Ерөнхий чиг үүрэг-1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, удирдлага, зохицуулалтаар хангах болон судалгаа, шинжилгээ хийх<sup>1</sup></b>						
<b>Үндсэн чиг үүрэг-1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах<sup>2</sup></b>						
1.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулна	1.1. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулна.	Боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийн тоо  /Тоо/	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан.	Хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна.  /Нийт 6 баримт бичиг/	-	Үйл ажиллагааны зардлаар
	1.2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулна		Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталсан.	Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан байна.  /Нийт 1 баримт бичиг/	-	
	1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулна		Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан байна.  /Нийт 1 баримт бичиг/	-	

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20.5.2 дахь заалт<sup>2</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9.4.2 дахь заалт

	1.4. Богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батвруулна.		Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-г баталсан.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүр боловсруулсан байна.  /Нийт 2 баримт бичиг/	-	
<b>Үндсэн чиг үүрэг 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах</b>						
2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад удирдлага, зохицуулалтаар хангах, дэмжлэг үзүүлнэ	2.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулна	Боловсруулсан төслийн тоо  /Тоо/	-	Холбогдох журмын төслийг боловсруулсан байна.  /Нийт 1 журмын төсөл/	-	Үйл ажиллагааны зардлаар
	2.2. Аймаг, нийслэлийн даргын ажллагааны хөтөлбөрт өгө	Засаг үйл санал  /Хувь/	Хөтөлбөрийг боловсруулан, санал авахаар ирүүлсэн төслүүдэд тухай бүр санал хүргүүлсэн.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17.2-т зааснаар "Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл"-д тухай бүр санал өгсөн байна.  /100 хувь/	-	
	2.3. Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар	Жил бүр улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх  /Давтамж/	Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2020 онд зөвшөөрөл өгсөн.	Улсын төсвийн төслийг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, жил бүр зөвшөөрөл өгсөн байна.  /Нийт 3 удаа/	-	

	зөвшөөрөл өгнө.					
	2.4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллана	Мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан байх  /Хувь/	-	Мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан байна.  /100 хувь/	-	
<b>Үндсэн чиг үүрэг – 3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх<sup>3</sup></b>						
3.Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох, судалгаа, шинжилгээ хийнэ <sup>4</sup>	3.1.Үндэсний хөгжлийн хүрээлэн-Засгийн газрын тинктанк байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын барилга барина.	Судалгаа, дүн шинжилгээ, төсөв, тооцоо хийсэн байх  /Хувь/	Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулах суурь судалгаа хийгдсэн.	Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн барилгыг барьсан байна.  /100 хувь/	69,000.0	Улсын төсөв
4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад	4.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд	Судалгааны тоо  /Тоо/	2020 онд энэ чиглэлээр 2 судалгаа хийсэн.	Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого,	-	Үйл ажиллагааны зардлаар

<sup>3</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 7.3, 9.12 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 28.4 дахь хэсэг

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.2 дахь зорилт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.2.2.

дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ хийнэ	чиглэлээр шаардлагатай судалгаануудыг тухай бүр хийсэн байна			төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай судалгааны тайлан гарсан байна. /Нийт 48 судалгаа/		
5.Хууль тогтоомжид заасны дагуу холбогдох журам, дүрэм, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулна <sup>5</sup>	5.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан болон нэмж тусгах төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэн, суурь судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	Суурь судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг нь боловсруулсан төслийн тоо /Тоо/	2020 онд 2 төслийн суурь судалгаа, 1 төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулсан.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан болон нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. /Нийт 66 төслийн суурь судалгаа, 66 төслийн ТЭЗУС, ТЭЗҮ/	800.0	Улсын төсөв
